



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 214 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг эрчимжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч:	Н.Ганболд	- Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга;
Гишүүд:	Д.Дэлгэрмаа	- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
	Ц.Баяр-Эрдэнэ	- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга;
	Д.Нарангэрэл	- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга;
	Ц.Түвшинзаяа	- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга;
	Д.Будхүү	- Мэдээлэл, технологийн албаны дарга
	В.Дарханбаатар	- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны ахлах мэргэжилтэн (Албаны дарга);
	Ц.Шинэхүү	- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны ахлах мэргэжилтэн (Албаны дарга);
	Х.Энхчимэг	- Захиргаа, удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн;
	Д.Одмаа	- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
	Д.Цэрэнлхам	- Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн;
	Ц.Эрдэнэцэцэг	- Захиргаа, удирдлагын хэлтсийн Бичиг хэргийн ажилтан;

ТӨБЗГ тушаал-/2022

132013423

Нарийн Н.Дагиймаа - Захиргаа, удирдлагын хэлтсийн Хүний
бичиг: нөөцийн мэргэжилтэн.


2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх асуудлаар чиглэл өгч, шийдвэрлэлтийн дүн, мэдээг хүлээн авах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгөх мэдээнд нэгтгэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

4.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг өдөр тутам танилцуулж байхыг Ажлын хэсгийн ахлагч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/70 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

1. Ажлын хэсэг нь Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 214 дүгээр тогтоолоор баталсан удирдамжид заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэл ажиллана.

2. Ажлын хэсэг нь иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, шуурхай шийдвэрлүүлнэ. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв "11-11"-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг хамааруулна.

3. Шаардлагатай тохиолдолд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд тусгагдсан асуудлыг чиг үүргийн хүрээнд судалж, өргөдөл, гомдол гаргагч иргэнийг хүлээн авч уулзах замаар шуурхай шийдвэрлэж, хариуг өгнө.

4. Иргэдээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт болон харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг тухай өдрийн 15:30 цагаар тасалбар болгон холбогдох маягтын дагуу нэгтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох албан тушаалтны цахим шуудан, утсаар мэдээлнэ.

5. Тухайн өдөр шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг газрын даргад өдөр бүр 16:30 цагт танилцуулна.

6. Ажлын хэсгийн нарийн бичиг нь Ажлын хэсгийн дарга, гишүүдийн холбоо барих утасны нэгдсэн жагсаалт, амралтын өдөр ажиллах хуваарийг гаргаж, бэлтгэсэн байна.

7. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан тушаалтнууд холбоо барих гар утсыг 24 цагаар нээлттэй байлгана.

----- о О о -----